



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 13

Мандалговь

С.Отгонбаярыг Дэрэн сумын Засаг даргын
Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан
мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Содномпилын Отгонбаяр 18.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа С.Отгонбаярын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны
асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд
нэр дэвшүүлсэн С.Отгонбаярын тухай дүгнэлт**

1. С.Отгонбаяр нь 1989 онд Дундговь аймгийн Говь-Угтаал суманд төрсөн. 33 настай, эрэгтэй
2. Боловсрол: 2007-2011 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг агнуурын биологич мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2012 оноос эхлэн Дэрэн сумын Засаг даргын Тамгын газарт Хөдөө аж ахуйн мэргэжилтнээр ажиллаж байгаа.
4. С.Отгонбаярын тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Дэрэн сумын Засаг даргын Тамгын газрын Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ